



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 10 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27.3.3, 27.3.7 дахь заалтуудыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

Нэг. “Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх
арилжааны банктай хамтран ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын
үндэсний зөвлөлийн ажлын алба /Х. Алимаа/-нд даалгасугай.

ДАРГА

Д. НЯМХҮҮ

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2010 оны 12 дугаар сарын 27-ний
өдрийн 25 дугаар тогтоолын хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР,
ТЭТГЭМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АРИЛЖААНЫ
БАНКТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, эмчилгээ, үйлчилгээний төлбөр олгох үйлчилгээг /цаашид “Нийгмийн даатгалын үйлчилгээ” гэх/ арилжааны банкаар дамжуулан үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Нийгмийн даатгалын сангудын төлбөр тооцоог гүйцэтгэхдээ Нийгмийн даатгалын тухай хууль, Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг мөрдлөг болгоно.

1.3. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Нийгмийн даатгалын байгууллага нь банкны байгууллагаар дамжуулан Нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлэхдээ тухайн банкны дүрмийн сангийн өмчлөл, үүсгэн байгуулагдсан хэлбэрээс үл хамааран хууль, тогтоомжид заасан шаардлага зарчмыг адил тэгш баримтлах бөгөөд харилцах дансны үлдэгдэлд хүү тооцох, үйлчилгээний хөлс тогтоох болон бусад зүйлд тусгайлан шаардлага тавьж, хязгаарлалт хийж болно.

Хоёр. Арилжааны банктай хамтран ажиллах

2.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх арилжааны банктай ерөнхий зарчмыг тохирсон хамтран ажиллах гэрээ /цаашид “ерөнхий гэрээ” гэх/-г жил бүр байгуулна.

2.2. Нийгмийн даатгалын хэлтэс нь “ерөнхий гэрээ”-г үндэслэн тухайн орон нутаг дахь тухайн банкны салбар нэгж нь дараах шаардлагыг хангасан тохиолдолд “хамтран ажиллах гэрээ”-г байгуулж ажиллана. Үүнд:

- 2.2.1. Нийгмийн даатгалын үйлчилгээг тухайн банкны аль ч салбар, тооцооны төвөөс түргэн шуурхай, чанартай үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх;
- 2.2.2. Нийгмийн даатгалын үйлчилгээний ая тухтай нөхцөл бүрдүүлсэн болон олон төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой байх;
- 2.2.3. Байршлын хувьд тохиромжтой байдлыг харгалзах;
- 2.2.4. Даатгалын сангийн орлого, зарлагын гүйлгээг хямд чирэгдэлгүй, түргэн шуурхай гүйцэтгэх боломжтой байх;
- 2.2.5. Нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын гүйлгээг цахим хэлбэрээр хийх, хуулгыг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн байх;

- 2.2.6. Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх банк нь өөрийн биеэр ирж тэтгэврийн мөнгөө авах боломжгүй, хэт өндөр настай болон хэвтрийн өвчтэй иргэдэд гэрээр үйлчлүүлэх боломжийг хангасан байх;
- 2.2.7. Хэлтсийн харилцах дансанд тооцох хүүгийн хэмжээ нь ерөнхий гэрээнд тусгаснаас багагүй байх;
- 2.2.8. Тэтгэвэр авагчдын тэтгэврийн харилцах дансанд тооцох хүүг тусгасан байх
- 2.2.9. Банкны үйлчилгээний хураамжийн хэмжээ нь ерөнхий гэрээнд тусгаснаас ихгүй байх;
- 2.2.10. Нийгмийн даатгалын зохих сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эмчилгээний зардлын тухайн сарын эх үүсвэр дутагдах тохиолдолд дутагдсан хөрөнгийн хэмжээгээр хүүгүй, хоёр долоо хоног хүртэл түр хугацааны санхүүжилтийг олгох боломжтой байх.

2.3. Тухайн аймгийн нийт тэтгэвэр, тэтгэмж авагчдын 60-аас дээшгүй хувь нэг банкинд төвлөрөхгүй байхаар банкны салбар нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулна.

2.4. Тэтгэвэр, тэтгэмж авагч Нийгмийн даатгалын үйлчилгээг ямар банкны салбар нэгжээр авахаа өөрийн хүсэлтээр сонгон үйлчлүүлэх боломжийг Нийгмийн даатгалын хэлтэс бүрдүүлсэн байна.

Гурав. Тэтгэвэр, тэтгэмж олгох үйлчилгээ

3.1. Нийгмийн даатгалын хэлтэс нь “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулсан банкаар дамжуулан үндэслэн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг үзүүлнэ. “Хамтран ажиллах гэрээ”-нд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээний талаар нарийвчилсан зохицуулалтыг тусгасан байна.

3.2. Нийгмийн даатгалын хэлтэс нь тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусlamж үйлчилгээний зардал, дансны үлдэгдэл, банкны үйлчилгээний хураамж зэргийг сар бүр банктай тооцоо нийлж, акт үйлдэж баталгаажуулна.

3.3. Нийгмийн даатгалын хэлтэс нь “Хамтран ажиллах гэрээ”-ний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газар ирүүлнэ.

---ooOoo---